



2018 ОНЫ I УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

**ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР**



Улаанбаатар хот
2018 он

АГУУЛГА

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА.....	2
1.1 Салбарын үзүүлэлтүүд	2
1.1.1 Үнэт цаасны зах зээл.....	2
1.1.2 Даатгалын салбар.....	4
1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага.....	6
1.1.4 Хадгаламж зээлийн хоршоо	7
2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ	8

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн утга, ангилал	3
Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	3
Хүснэгт 3. Даатгалтай холбоотой ирсэн өргөдлийн утга, ангилал.....	4
Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл	4
Хүснэгт 5. Даатгалтай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	5
Хүснэгт 6. Урьдчилан шийдвэрлэгдсэн нөхөн төлбөрийн дүн.....	6
Хүснэгт 7. ББСБ-тай холбоотой өргөдөл.....	6
Хүснэгт 8. ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт.....	7
Хүснэгт 9. ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн товч утга	7
Хүснэгт 10. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал	8

ДҮРСЛЭЛ


Дүрслэл 1. СЗХ-нд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо (улирлаар)	2
Дүрслэл 2. Зөвшөөрөлгүй хувьцаа арилжаалсан тухай өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	3
Дүрслэл 3. Өргөдөл гомдолд хамааралтай даатгалын компаниуд.....	5
Дүрслэл 4. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)	8

1. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2018 оны I улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 92 өргөдөл гомдол ирсэн байна.

Дүрслэл 1. Өргөдөл, гомдлын тоо (улирлаар)



Тус Хороонд 2018 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ийнхүү нэмэгдсэн нь тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлтэй холбоотой 21.7 хувиар, ББСБ-тай холбоотой өргөдөл, гомдол гаргачдын тоо 80.0 хувиар өссөнтэй холбоотой.

1.1 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2018 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

1.1.1 Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой нийт 28 өргөдөл, гомдол ирснээс 7 нь хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж, 16 өргөдөл хянагдах шатанд байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 1. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн утга

Д/д	Товч утга	2017/ I тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/ I тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	16	69.5%	12	43.0%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээллийг шалгуулах	3	13.0%	7	25%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	-	-	1	3.5%
4	Хувьцаа эзэмшигчийн нэр зөрсөн	-	-	1	3.5%
5	Данс нээлгэх тухай	-	-	2	7.0%
6	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	3	13.0%	1	3.5%
7	Бусад	1	4.5%	4	14.5%
	Нийт	23	100%	28	100%

Дээрх өргөдлийн 43.0 хувийг брокер, дилерийн компаниар дамжуулан эзэмшигчийн зөвшөөрөлгүй арилжаалагдсан хувьцаатай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байгаа бөгөөд үүнээс 58.0 хувийг өмнө нь Хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 7 брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалсан байна. Энэ тохиолдлоор өргөдөл гаргагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Тус Хороонд үнэт цаасны зах зээлийн байгууллагуудтай холбоотой ирүүлсэн ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар урьдчилан шийдвэрлэв.

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн утга	2018/ I
1	Хорооноос үүрэг, даалгавар хүргүүлсэн	2
2	Хууль, хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх	10
3	Албан бичгээр холбогдох хариу өгч шийдвэрлэсэн	15
4	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	1
	Нийт	28

Ирсэн өргөдөл, гомдлыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦГХТ” ХХК, үнэт цаасны компани болон шаардлагатай тохиолдолд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагуудаас тайлбар, баримт материалыг гаргуулан авч тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэдэг.

Дүрслэл 2. Зөвшөөрөлгүй хувьцаа арилжаалсан тухай өргөдөл, гомдлын шийдвэрлэлт



Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан тохиолдлууд нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах учир Зөрчил, шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу ажиллагаа явуулан хянан шийдвэрлэдэг. Тайлант хугацаанд дээрх тохиолдлоор ирүүлсэн өргөдөл, гомдлын 83.0 хувийг нь хувьцаа худалдах захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөлд нэр бүхий гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийг хуурамч болохыг эрх бүхий байгууллагаар тогтоолгох, мөн 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, гомдолд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогдоогүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар холбогдох шүүх, хяналтын байгууллагад хандуулахаар урьдчилан шийдвэрлэжээ.

Хорооноос өгсөн үүрэг, даалгавар түүний биелэлтийн тухайд, “Улаанбаатар хивс” ХК, “Тахь ко” ХК-ийн хувьцааг харилцагчийн дансанд буцаан байршуулах 2 удаагийн хугацаатай үүрэг, даалгаврыг холбогдох үнэт цаасны компанид хүргүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн харилцагчийн дансанд "АПУ" ХК-ийн 40,000 ширхэг хувьцааг буцаан байршуулав.

1.1.2 Даатгалын салбар

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 40 өргөдөл, гомдол ирсний хугацаандаа шийдвэрлэгдсэн 39, харин 1 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна. Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 3. Даатгалтай холбоотой ирсэн ирсэн өргөдлийн утга, ангилал

Д/д	Өргөдөл, гомдлын товч утга	2017/ I тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/I тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	28	67%	28	70%
2	Нөхөн төлбөр олгоггүй удаасан	2	5%	3	7.5%
3	Нөхөн төлбөрийг хасч олгосон	6	14%	4	10%
4	Даатгалын хураамжийн маргаан	-	0%	2	5%
5	Бусад	6	14%	3	7.5%
	Нийт	42	100%	40	100%


Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 4. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл

Д/д	Даатгалын төрөл	2017/ I тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/I тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	13	30.9%	5	12.5%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	13	30.9%	13	32.5%
3	Орон сууц зээлдэгчийн эрсдэлийн даатгал	8	19.0%	11	27.5%
4	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	-	-	1	2.5%
5	Хөрөнгийн даатгал	1	2.4%	3	7.5%

6	Мал амьтны даатгал	1	2.4%	3	7.5%
7	Ачаа, тээврийн даатгал	-	-	1	2.5%
8	Хариуцлагын даатгал	1	2.4%	-	-
9	Санхүүгийн даатгал	1	2.4%	-	-
10	Бусад	4	9.6%	3	7.5%
	Нийт	42	100%	40	100%

Дүрслэл 3. Өргөдөл гомдолд хамааралтай даатгалын компаниуд



Хүснэгт 5. Даатгалтай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл, гомдолд хамааралтай даатгалын компани	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлтэй	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан нь үндэслэлгүй	Шүүхэд хандан шийдвэрлүүлэх	Өргөдөл шийдвэрлэх явцад нөхөн төлбөр олгогдсон
1	"Бодь даатгал" ХХК	1	1	-	-
2	"Мандал даатгал" ХХК	6	2	1	-
3	"Миг даатгал" ХХК	1	-	-	1
4	"Монре даатгал" ХХК	1	-	1	-
5	"Номин даатгал" ХХК	-	1	-	-
6	"Соёмбо даатгал" ХХК	2	1	-	1
7	"Тэнгэр даатгал" ХХК	3	-	3	-
8	"Хаан даатгал" ХХК	1	2	-	-
9	"Практикал даатгал" ХХК	4	-	1	1
	Нийт	19	7	6	3

Тайлант хугацаанд Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд урьдчилан шийдвэрлэж, даатгуулагч, үйлчлүүлэгч 8 иргэн, хуулийн этгээдийн нөхөн төлбөрт нийт 356,265,389.00 (Гурван зуун тавин зургаан сая хоёр зуун жаран таван мянга гурван зуун наян есөн) төгрөгийг олгуулах шийдвэрийг гаргаж, үүнээс 4 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт 99,650,589.00 (Ерэн есөн сая зургаан зуун тавин мянга таван зуун наян есөн) төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулав.

Хүснэгт 6. Урьдчилан шийдвэрлэгдсэн нөхөн төлбөрийн дүн

Д/д	Холбогдох даатгалын компани	Иргэн, хуулийн этгээд	Олгохоор шийдвэрлэсэн дүн	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн
1	“Бодь даатгал” ХХК	1	16,447,000.00	
2	“Номин даатгал” ХХК	1	2,905,200.00	2,905,200.00
3	“Соёмбо даатгал” ХХК	2	95,543,689.00	95,543,689.00
4	“Хаан даатгал” ХХК	2	241,017,000.00	1,017,000.00
5	“Мандал даатгал” ХХК	1	352,500.00	
6	“Миг даатгал” ХХК	1		184,700.00
	Нийт	8	356,265,389.00	99,650,589.00

Дүгнэхэд, даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсантай холбоотой өргөдлийн 67.8 хувийг даатгалын компанийн зүгээс нөхөн төлбөр олгохоос үндэслэлтэйгээр татгалзсан тохиолдол эзэлсэн байна.

1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага

Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 18 өргөдөл гомдол ирсний 11 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, хугацааг сунган хянагдаж буй 3, харин 4 өргөдөл гомдол хуулийн хугацаанд хянагдаж байна.

Хүснэгт 7. ББСБ-тай холбоотой асуудлаар ирүүлсэн өргөдөл

Д/д	Өргөдөл гомдлын товч утга	2017/ I тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/I тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл	2	20.0%	7	39.0%
2	Зээл болон хүүгийн тооцоолол	4	40.0%	3	16.7%
3	Барьцааны зүйл чөлөөлүүлэх	-	-	2	11.1%
4	Зээлийн гэрээний маргаан	2	20.0%	1	5.5%
5	ББСБ-ын үйл ажиллагаа	1	10.0%	1	5.5%
6	Лавлагаа	-	-	1	5.5%
7	Бусад	1	10.0%	3	16.7%
	Нийт	10	100%	18	100%

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнхийг буюу 39.0 хувийг Зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээллийг шинэчлээгүйгээс зээлийн ангилалд сөргөөр нөлөөлсөн тухай өргөдөл эзэлж байна.

Мөн зээлийн хүү болон нэмэгдүүлсэн хүүг буруу тооцсон, барьцаа хөрөнгийг чөлөөлөөгүй, зээлийн гэрээг тухайн ББСБ өөртөө давуу эрх олгох байдлаар байгуулсан гомдлууд 33.3 хувийг эзэлжээ.

Хүснэгт 8. ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын шийдвэрлэлт

Д/д	Өргөдөл гомдол шийдвэрлэсэн утга	2018/І
1	Хорооноос үүрэг даалгавар хүргүүлсэн	4
2	Хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлэх	3
3	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага оногдуулсан	1
4	Холбогдох хариу өгч шийдвэрлэсэн	6
5	Хуулийн хугацаанд хянагдаж байгаа	4
	Нийт	18

Дээрх өргөдөл, гомдлыг урьдчилан шийдвэрлэх явцад дараахь арга хэмжээг авав:

1. “Сера интернэшнл ББСБ” ХХК-д зөрчлийн хэрэг нээн Зөрчлийн тухай хуулийн 15.2 ийн 1.1 дэх хэсгийн дагуу 500,000.0 төгрөгийн шийтгэл оногдуулсан.

2. “Номин карт ББСБ” ХХК, “Номин юнион” ХЗХ-той холбоотой гомдлыг хүлээн авч 19 дугаартай зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах тухай тогтоол үйлдэж УЕП-т хүргүүлж танилцуулав.

3. Нэр бүхий 3 иргэний Зээлийн мэдээллийн сан дахь мэдээллийг шинэчлэх үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулсан.

4. Нэр бүхий 1 иргэний зээлийн нэмэгдүүлсэн хүүг хуулийн дагуу тооцоолох үүрэг даалгаврыг холбогдох ББСБ-д хүргүүлж, биелэлтийг хангуулсан болно.

1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан Хороонд нийт 6 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 9. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдлийн товч утга

Д/д	Товч утга	2017/ I тоо хэмжээ	Эзлэх хувь	2018/І тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Лавлагаа гаргуулах	2	40%	4	66.6%
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-	1	16.6%
3	ХЗХ-дын үйл ажиллагаа	3	60%	-	-
4	Бусад	-	-	1	16.6%
	Нийт	5	100%	6	100%

Дээрх өргөдөл, гомдлыг урьдчилан шийдвэрлэх явцад “Монкорд” ХЗХ-ны нэр бүхий 1 гишүүний хадгаламжийг буцаан байршуулах тухай үүрэг даалгавар өгч, Зөрчлийн тухай хуулийн 11.8-ын 1.1 дэх хэсэгт заасны дагуу тус Хоршоонд 2,000,000.0 төгрөгийн торгууль оногдуулсан.

2. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ


Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 92 өргөдөл, гомдол ирснээс:

Хүснэгт 10. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Шийдвэрлэсэн байдал	Тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	67
<i>Хугацаанд нь шийдвэрлэсэн</i>	64
<i>Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн</i>	3
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	25
<i>Хуулийн хугацаанд хянагдаж буй</i>	15
<i>Хугацааг нь сунган хянагдаж буй</i>	10

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 21 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Дүрслэл 4. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)



ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР